



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

XVI ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын XVI хурал 2020 оны 04 дугаар сарын 11-ны өдрийн 13.00 цагаас Төрийн ордон дахь Монгол Улсын Шадар сайдын ажлын өрөөнд 65 хувийн ирцтэйгээр хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар;

*Улсын онцгой комиссын гишүүн,
Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл*

2. Гадаад улс орнуудаас эх орондоо ирэх Монгол Улсын иргэдийг татан авчрах, тусгаарлах ажлыг зохион байгуулах талаар;

*Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Т.Бадрал*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

А. Сүүлийн үед иргэд олон нийтийн дунд КОВИД-19 халдварын болзошгүй аюулаас сэргийлэх хандлага суларч байгаа тул халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх ажлыг чангатгах зорилгоор улс орон даяар “Маскаа зүүцгээе” аяныг зохион байгуулахаар тогтов.

Нэг. Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
хошууч генерал Т.Бадрал,
Зам, тээвэр хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,
Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,
Хил хамгаалах ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн,
Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү нарт:

1.1. ОХУ-аас хилийн боомтоор орж ирэх Монгол Улсын иргэдийг 2020 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр нэгдсэн зохион байгуулалттайгаар эх орондоо татан авчрах, тусгаарлах ажлыг шуурхай зохион байгуулах;

1.2. Улсын онцгой комиссын 14 дүгээр тэмдэглэлийн 1.2 дахь заалтын хэрэгжилтэд онцгой анхаарч ажиллах;

Хоёр. Улсын онцгой комиссын
Шуурхай штабын дарга, хурандаа Б.Ууганбаяр:

2.1. “КОВИД-19 халдварын үед иргэнийг тусгаарлах, ажиглах түр журам”-ыг зөрчсөн иргэдэд ногдуулах хариуцлагын арга хэмжээг чангатгах санал боловсруулж, Улсын онцгой комиссын даргаар батлуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

Гурав. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,
Сангийн сайд Ч.Хүрэлбаатар,
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт:

3.1. Гадаад улс орнуудаас эх орондоо ирэхээр хүсэлт гаргасан, санхүүгийн хувьд хүнд байдалд орсон Монгол Улсын иргэдэд нэг удаагийн амьжиргааны тэтгэмж олгох асуудлыг судлан, Улсын онцгой комиссоор хэлэлцүүлэн, Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэх;

Дөрөв. Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж,
Цагдаагын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн бригадын генерал С.Баатаржав
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү нарт

4.1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед Улсын онцгой комиссоос гарсан шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангах, иргэдийн

хариуцлагыг өндөржүүлэх, төрийн болон олон нийтийн хяналтыг чангатгах, зөрчил гаргасан иргэд, хуулийн этгээдэд хариуцлага тооцох эрхийг нэмэгдүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж, Улсын онцгой комисст танилцуулах;


Тав. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

5.1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудын үйл ажиллагааг түр зогсоосонтой холбогдуулан хүүхэд, багачуудын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хот, суурин газрын ойролцоо байрлах хүүхдийн амралт, сувиллын газруудын үйл ажиллагааг тусгай горимын дагуу сэргээх асуудлыг судлан, шийдвэрлүүлэх;

5.2. Хаврын улирал эхэлж байгаатай холбогдуулан КОВИД-19-ын халдварын тархалт, шар усны үер, орчны болон хөрсний бохирдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдийн оршин суугаа байр, нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, нийтийн тээвэр, худалдаа үйлчилгээний газруудын ариутгал, халдваргүйжүүлэлт, нийтийг хамарсан цэвэрлэгээний ажлыг эрчимжүүлэх;

5.3. КОВИД-19-ын халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор хот хоорондын автозамын шалган нэвтрүүлэх товчоо цэгүүдээр дамжин өнгөрөх зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тавих хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх;

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



Ө.ЭНХТҮВШИН

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Г.АРИУНБУЯН